



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 15

Хараат

Г Малын тоо толгойн албан татварын
хэмжээнд хөнгөлөлт үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Татварын өрөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. 2020-2021 онд тохиолдсон цаг агаарын гамшгийн улмаас өвөлжилт, хаваржилт хүндэрч мал олноор хорогдож, малчид отор нүүдэлд ихээхэн хөрөнгө зарцуулж санхүүгийн хүндрэл үүссэн зэргийг харгалзан 2021 онд ногдуулсан малын тоо толгойн албан татварын хэмжээг 50 /тавы/ хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлсүгэй.

2. Малын тоо толгойн албан татварыг холбогдох баримт бичгийг үндэслэн үнэн зөв, бодитой тогтоож төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга (Д.Буджав), татварын байцаагч (Ц.Энх-Амгалан) нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮРКИЙН
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ХҮРЭЛХУЯГ
Хуралдааны тогтоолын хэрэгжилтийн талбай

Бүртгэлийн дугаар	18
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХУУЛБАР ҮНЭН	
Хуулбар олгосон ажилтын гарын үсэг	
2021 оны 12 сарын 07-ний өдөр	

